21	Бараа үйлчилгээний зардал	40,000,000.00	40,000,000.00		100%
2104	Хангамж бараа материалын зардал	40,000,000.00	40,000,000.00		100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ахиутгал	40,000,000.00	40,000,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	354,961,575.00	255,597,843.00	99,363,732.00	72.0%
	Дотоод эх үүсвэрээр	354,961,575.00	255,597,843.00	99,363,732.00	72.0%
	Бусад хөрөнгө	354,961,575.00	255,597,843.00	99,363,732.00	72.0%
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа, зорилго, зорилт

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар хангах, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, чанар хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан болох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын болон татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 918,150.8 мянган төгрөгөөр буюу 52.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	85,487.70	103,107.70	17,620.00
Үндсэн хөрөнгө	1,654,969.30	2,555,500.10	900,530.80
Нийт хөрөнгө	1,740,457.10	2,658,607.80	918,150.80
Өр төлбөр		123,148.90	123,148.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,740,457.10	2,535,459.00	795,001.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,740,457.10	2,658,607.80	918,150.80

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардлын эхний, эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 103,107.7 мянган төгрөг болж 17,620.0 мянган төгрөгөөр өссөн нь сумын 100 жилийн ойтой холбоотойгоор бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,555,500.1 мянган төгрөг болж 900,530.8 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 396,137.2 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 383,634.4 мянган, хандиваар 365,700.0 мянган төгрөгийн тоног

төхөөрөмж нэмэгдэж, тайлант онд 242,366.5 мянган төгөөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, 98,098.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 123,148.9 мянган төгрөг байгаа нь санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс үүссэн тээвэр шатахуун, түлш халаалт, бараа үйлчилгээний бусад зардал, Нийгмийн даатгалын шимтгэл, хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн өр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,535,459.0 мянган төгрөг болж 795,001.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 741372,3 мянган төгрөгөөр буюу 66.6 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, үндсэн үйл ажиллагааны орлого голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 195,782.4 мянган төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна. Зарлага өссөн шалтгаан нь сумын 100 жилтэй холбоотойгоор урсгал засварын зардал нэмэгдсэн, сум, баг, байгууллагын засвар хийсэн нь голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,303,136.8 мянга, зарлагыг 1,303,136.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 249,490.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,053,646.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 19,919.3 мянган төгрөгөөр хасаж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,033,727.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,033,727.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Зарцуулаагүй үлдэгдэл 131,448.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Үндсэн үйл ажиллагааны зардал -80101	587,203.60	583,771.40	3,432.20	99.4%
2	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Баг хорооны үйл ажиллагааны зардал -80106	169,992.80	168,685.20	1,307.60	99.2%
3	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Төрийн өмчийн барилгын тогомол зардал -80111	128,108.30	123,423.80	4,684.50	96.3%
4	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Нийтлэг үйлчилгээ- 80112	84,348.10	82,383.20	1,964.90	97.7%
5	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Ажил олгогчоос олгох тэтгэмж -80802	10,045.00	1,625.00	8,420.00	16.2%
6	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Орон нутгийн нөөц хөрөнгө -81102	46,372.10	45,017.75	1,354.30	97.1%
7	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Мал тооллого -81507	850.00	-	850.00	

8	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Хур хог хаягдал , орчны бохирдол -82212	450.00	440.00	10.00	97.8%
9	ОН -гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Улсын их баяр наадам -82801	5,000.00	5,000.00	-	
10	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх - 71413 Байгаль орчныг хамгаалах -81701	16,548.90	16,533.60	0.15	99.9%
11	Ахмад настны хөгжлийн хамгаалах -72208 Ахмадын сан -81549	600.00	600.00		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/					
№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл		2,355.0		Санхүүгийн Acolous, архив бичиг хэргийн программ
2	Унаа, хоолны зардал		0.0		Зардал гараагүй.
3	Сургалт, семинар		0.0		Зардал гараагүй.
4	Гадаад томилолт, арга хэмжээ		0.0		Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		0.0		Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол		0.0		Орон тооны цомхотгол хийгээгүй
7	Хэвлэл, мэдээлэл		0.0		Зардал гараагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах аймаг орон нутгийн байгууллагын шийдвэрээр нийт 419,097.2 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,516.9 мянга, нийт 421,614.2 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас тээвэр шатахууны зардалд 1,443.3 мянга, урсгал засварын зардалд 5,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянга, үндсэн цалин 514.5 мянга, тэтгэврийн даатгал 59.1 мянга, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал 40,000.0 мянга, бусад хөрөнгийн зардалд 255,597.8 мянга, нийт 304,614.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 116,999.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засаг даргын тамгын газар нь тайлант онд 3 тендер, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд: Наадмын талбай 197,582.2 мянган төгрөгийн өртгөөр Хүрэл буян ХХК, Хүрэн морьтын давааны зам 85,065.1 мянган төгрөгийг өртгөөр Мажестик солюшн рөүд ХХК, Хар хэмийн давааны зам 89,949.9 мянган төгрөгөөр Мажестик солюшн рөүд ХХК тус тус тендерт шалгарч худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Мөн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж бичиг хэрэг, аж ахуйн материал түлш шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, бусад хамнамжийн материалыг нийт 142,023.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүрий худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,231,389.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 12,313.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,851.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,427,171.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,271.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,417.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Малчин сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3,300.0 мянга, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1,000.0 мянга, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах бэлэг дурсгалын зүйл авахад 2,000.0 мянга, нийт 6,300.0 төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 166 хугацаа хоцроож оруулсан 3 мэдээлэл, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дах хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкттай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкттай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картан данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картан дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас

зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасан байна.

Тайлант онд Малчин сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 4,000.0 мянган төгрөгийн гүйлгээг байгууллагын картын данс байхгүйн улмаас хувь хүний дансаар дамжуулан зарцуулсанд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж илэрсэн зөрчилд асуудлын бүртгэл хөтөлж албажуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зориулалт бусаар зарцуулсанд 4,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, анхан шатны баримтаар нотлогдсон өр төлбөр, үүссэн авлагыг санхүүгийн тайланд бүрэн тусгаж тайлагнах 3,120.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь хэсэгт “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс” бүрдэнэ гэж заасантай нийцэхгүй байх тул дараагийн аудитаар тухайн зөрчлийг арилган ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.
2. Малчин сумын Засаг даргын тамгын газраас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй 3 багийн сахиул, олон нийтийн цагдаа, сантехникч, нийт 5 ажилтныг гэрээтээр ажиллуулж байна. Дараагийн аудитаар тухайн гэрээт ажилтнуудын орон тоог Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.
3. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр аймагт ажиллахдаа Малчин сумын Засаг даргын тамгын газарт өсгөн Ковш тракторыг холбогдох баримт бичиг ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна. Дараагийн аудитаар данс бүртгэлд тусгасан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,300.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,300.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө. Мөн 173.5 мянган төгрөгийн залруулга хийлгэсэн.

Залруулсан алдаа:

Орон нутгийн өмчийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр данснаас хасах хөрөнгийн жагсаалтад оруулсан Малчин сумын Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд байсан Багийн төвийн конторын барилга 173.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.1 Албан шаардлага

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3,300.0 мянга, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1,000.0 мянга, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах бэлэг дурсгалын зүйл авахад 2,000.0 мянга, нийт 6,300.0 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалт болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг мөрдөж ажиллах, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй ажиллахыг албан шаардлага болгов.

5.2 Зөвлөмж

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Малчин сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 4,000.0 мянган төгрөгийн гүйлгээг хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид хувь хүний дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө илүү илэрхийлсэн	1	173.5			1	173.5	1	173.5				
Дүн	1	173.5			1	173.5	1	173.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй	1	6,300.0			1	6,300.0						
Дүн	1	6,300.0			1	6,300.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хууль, тогтоомж зөрчсөн	1	4,000.0					1	4,000.0
Дүн	1	4,000.0					1	4,000.0
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн Малчин сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2026/108/НА-СТА-ТШЗ
-----------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар		1.6 Огноо	2026.02.12	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	6,300,000
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	-----------

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Малчин сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3,300.0 мянга, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1,000.0 мянга, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах бэлэг дурсгалын зүйл авахад 2,000.0 мянга, нийт 6,300.0 төгрөгийг зарцуулсан байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль		
	Заалт	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”			

	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 дэх заалт
		Заалт	4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	
	Зөрчил арилгах	
		2026.05.05

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Засаг даргын захирамж	А/105	2025.06.16	Эх, үрсийн баярын арга хэмжээ
2	Холбогдох анхан шатны баримт		2025.06.16	Төлбөрийн хүсэлт, зарлагын баримт, фото зураг
3	Засаг даргын захирамж	А/148	2025.08.18	100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх
4	Холбогдох анхан шатны баримт		2025.08.18	фото зураг
5	Засаг даргын захирамж	А/107	2025.06.16	Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад
6	Холбогдох анхан шатны баримт		2025.06.16	фото зураг

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Ахлах аудитор	Т.Намжил	Малчин сумын ЗДТГ	Дарга	Ш.Баттулга	95456904
				Нягтлан бодогч	Ц.Нацаг	99305674

Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж
1	Аудитын менежер М.Бат-Амгалан	2026.02.25	—
2	Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	2026.02.25	—



4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2026.02.25



4. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо Дугаар		
2	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо	2026.02.12	
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Малчин сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	Ц.Нацаг
			Албан тушаал	Нягтлан бодогч
4	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Малчин сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	Ш.Баттулга
			Албан тушаал	Дарга
5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/25 /А2060412
УВА-2026/108/НА-СТА-ТМЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Арван баядын ноён уул болох Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3,300.0 мянга, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1,000.0 мянга, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах бэлэг дурсгалын зүйл авахад 2,000.0 мянга, нийт 6,300.0 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг мөрдөж, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга Ш.Баттулга, нягтлан бодогч Ц.Нацаг нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.НАМЖИЛ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ